

**СОНГОГЧИЙН НЭРСИЙН ЖАГСААЛТ,  
БҮРТГЭЛИЙН ХЯНАЛТЫН ДЭД ХОРООНЫ  
ХУРАЛДААНЫ ТЭМДЭГЛЭЛИЙН АГУУЛГА**  
*2024 оны 04 дүгээр сарын 26-ны өдөр, Баасан гараг*

<i>Хуралдааны тэмдэглэлийн агуулга</i>	<i>0</i>
<i>Хуралдааны товч тэмдэглэл:</i>	<i>1-1</i>
<i>Хуралдааны дэлгэрэнгүй тэмдэглэл:</i>	<i>2-3</i>
<hr/>	
<i>1. “Ажлын хэсэг байгуулах тухай” дэд хорооны тогтоолын төсөл</i>	<i>2-3</i>

**Монгол Улсын Их Хурлын 2024 оны хаврын ээлжит чуулганы  
Сонгогчийн нэрсийн жагсаалт, бүртгэлийн хяналтын дэд хорооны  
04 дүгээр сарын 26-ны өдөр /Баасан гараг/-ийн  
хуралдааны товч тэмдэглэл**

Сонгогчийн нэрсийн жагсаалт, бүртгэлийн хяналтын дэд хорооны дарга Ж.Батсуурь ирц, хэлэлцэх асуудлын дарааллыг танилцуулж, хуралдааныг даргалав.

Хуралдаанд ирвэл зохих 3 гишүүнээс 2 гишүүн хүрэлцэн ирж, 66.7 хувийн ирцтэйгээр хуралдаан 12 цаг 16 минутад Төрийн ордны “Их засаг” танхимд эхлэв.

Томилолттой: Ц.Мөнх-Оргил.

**Нэг. “Ажлын хэсэг байгуулах тухай” дэд хорооны тогтоолын төсөл**

Хуралдаанд Улсын Их Хурлын Тамгын газрын Хууль, эрх зүйн газрын Байнгын хорооны асуудал хариуцсан хэлтсийн Төрийн байгуулалтын байнгын хороо хариуцсан ахлах зөвлөх Б.Хатантуул, референт Э.Баттогтох нар байлцав.

Дэд хорооны дарга Ж.Батсуурь “Ажлын хэсэг байгуулах тухай” дэд хорооны тогтоолын төслийг танилцуулав.

Тогтоолын төсөлтэй холбогдуулан Улсын Их Хурлын гишүүн Г.Ганболд санал хэлэв.

**Ж.Батсуурь:** “Ажлын хэсэг байгуулах тухай” дэд хорооны тогтоолыг батлах санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 2  
Татгалзсан: 0  
Бүгд: 2  
100 хувийн саналаар дэд хорооны тогтоол батлагдлаа.

Дэд хорооны хуралдаанаар 1 асуудал хэлэлцэв.

Хуралдаан 8 минут үргэлжилж, 3 гишүүнээс 2 гишүүн хүрэлцэн ирж, 66.7 хувийн ирцтэйгээр 12 цаг 24 минутад өндөрлөв.

Тэмдэглэлтэй танилцсан:  
СОНГОГЧИЙН НЭРСИЙН ЖАГСААЛТ,  
БҮРТГЭЛИЙН ХЯНАЛТЫН  
ДЭД ХОРООНЫ ДАРГА

Ж.БАТСУУРЬ

Тэмдэглэл хөтөлсөн:  
ХУРАЛДААНЫ ТЭМДЭГЛЭЛ  
ХӨТЛӨХ АЛБАНЫ ШИНЖЭЭЧ

Э.СУВД-ЭРДЭНЭ

**МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРАЛ**  
2024 оны 04 дүгээр сарын 26-ны өдөр,  
Баасан гараг  
Төрийн ордон “Их засаг” танхим  
12 цаг 16 минут

**СОНГОГЧИЙН НЭРСИЙН  
ЖАГСААЛТ, БҮРТГЭЛИЙН  
ХЯНАЛТЫН ДЭД ХОРООНЫ  
ХУРАЛДААНЫ ДЭЛГЭРЭНГҮЙ  
ТЭМДЭГЛЭЛ**

**Ж.Батсуурь:** Бүгдээрэнд нь өдрийн мэнд хүргэе. Дэд хорооны гишүүдийн олонх хүрэлцэх ирсэн тул, ирц бүрдсэн гэж үзэж 2024 оны 04 дүгээр сарын 26-ны өдрийн хуралдаан нээж байна.

Дэд хорооны хуралдаанаар хэлэлцэх асуудлыг танилцуулъя.

Хэлэлцэх асуудал бол өмнөх 2 хуралдаан дээрээс яригдаж байсан. Тэгээд бас парламентад суудалтай голлох 2 намуудаас санал ирснийг үндэслээд ажлын хэсэг байгуулах тухай дэд хорооны тогтоолын төслийг танилцуулж байна.

Хэлэлцэх асуудал дээр саналтай гишүүд байна уу. Алга байна.

Хэлэлцэх асуудалдаа орёё. Тогтоолоо танилцуулъя. 2024 он өнөөдрийн дугаар. Улаанбаатар хот.

Ажлын хэсэг байгуулах тухай

Монгол Улсын Их Хурлын тухай хуулийн 28 дугаар зүйлийн 28.2.4 дэх заалт, 28.4 дэх хэсгийг үндэслэн Улсын Их Хурлын Сонгогчийн нэрсийн жагсаалт, бүртгэлийн хяналтын дэд хорооноос тогтоох нь:

Нэг. Сонгогчийн нэрсийн жагсаалт, бүртгэлийн талаарх холбогдох хууль, тогтоомжийн биелэлтийг хянан шалгахад дэмжлэг

үзүүлэх ажлын хэсгийг дараах бүрэлдэхүүнтэй байгуулсугай.

Ажлын хэсгийн ахлагчаар Д.Одхүү /Ардчилсан намын Ерөнхий нарийн бичгийн даргын зөвлөх/

Ажлын хэсгийн гишүүдэд Ж.Баярмаа /Ардчилсан намын дэд дарга/

Ж.Ган-Эрдэнэ /Монгол Ардын намын Ерөнхий нарийн бичгийн даргын зөвлөх/

Г.Эрдэнэбат /Ардчилсан намын даргын зөвлөх/

Д.Ядамжав /Улсын Их Хурал дахь Монгол Ардын намын бүлгийн ажлын албаны ахлах зөвлөх/

Хоёр. Сонгогчийн нэрсийн жагсаалт, бүртгэлийн талаарх хууль, тогтоомжийн биелэлтийн судалгаа хийх, холбогдох мэдээлэл авах, зохих албан тушаалтан, иргэн, байгууллагаас тайлбар авах ажлыг зохион байгуулж, үр дүнг 2024 оны 05 дугаар сарын 15-ны өдөр танилцуулахыг ажлын хэсэг /Д.Одхүү/-д даалгасугай гэсэн ийм тогтоол байна.

Тогтоолтой холбогдуулж асуулт асууж, үг хэлэх гишүүн байна уу. Ганболд гишүүн.

**Г.Ганболд:** Дэд хороо бол Улсын Их Хурлын бүтцийн байгууллага болох Төрийн байгуулалтын байнгын хороо дээр байгуулагддаг хороо. Энэ агуулгаараа бол бид нар төрийн ажил хийх ёстой. Энд орж ирсэн 5 нөхөр бол улс төрч байна. Тийм учраас энийг заавал Төрийн байгуулалтын байнгын хорооны зөвлөхүүдээс юм уу, хүмүүс оролцох ёстой. Энэ дотор орох ёстой. Төрийн байгууллагын бид нар хяналт хийх гэж байгаа байхгүй юу. Түүнээс улс төрч 4 хүн, 5 хүн орох юм бол энэ чинь хий попорсон, хоорондоо хэрэлдсэн ийм л юм болно шүү дээ.

Тэгэхээр улс төрийн намуудаас оруулах гэж байгаа бол ХҮН намаас 1-ийг оруул. Ардын намаас 1-ийг оруул. Ардчилсан намаас 1-ийг оруул. Төрийн байгууллагаас 2 хүн орох ёстой. Тэгж байж энэ ажлыг үнэн бодитойгоор явна болохоос хэт улс төрч байсан хүмүүс орж ирээд, тэгээд нийгэмд үнэн буруу мэдээлэл өгөөд л, тэгээд баахан ард түмнийг талцуулсан, хэрэлдүүлсэн юм болно гэж би шууд харж байна.

Тийм учраас Төрийн байгуулалтын байнгын хорооны даргатай зөвлөхүүд уулзаж, бүрэлдэхүүнд заавал төрийн хүмүүс орж байж, эргэж баталъя гэсэн саналтай байна.

**Ж.Батсуурь:** Ганболд гишүүний саналыг хүлээж аваад, ажлын хэсгийн ахлагчаар Одхүү, Ган-Эрдэнэ, Эрдэнэбат, Ядамжав, тэгээд Хатантуулыг оруулаад ингээд баталъя гэж бодож байна.

Тогтоолыг батлах санал хураалт явуулъя. Санал хураалт. Санал хураалт дууссан тул өнөөдрийн хуралдааныг хааж байна.

Санал хураалт 100 хувиар дэмжигдлээ. Өнөөдрийн дэд хорооны хуралдаанаар хэлэлцэх асуудал дууссан тул хуралдааныг хааж байна.

12.24 цаг.

**Дууны бичлэгээс буулгасан:**  
**ХУРАЛДААНЫ ТЭМДЭГЛЭЛ**  
**ХӨТЛӨХ АЛБАНЫ ШИНЖЭЭЧ**

Э.СУВД-ЭРДЭНЭ